

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

20... оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Үндэсний хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь заалтыг үндэслэн Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын 1.4.5, 2.1.2 7.1.1, 7.1.3, 7.1.7, 7.1.8 дахь зорилт, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.26, 2.28, 2.31 дэх зорилт, Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолын хэрэгжилтийг тус тус хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Монгол малчин” үндэсний хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай

2.Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2020 оны 1 дүгээр сард багтаан баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаанд даалгасугай.

3.“Монгол малчин” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусгах, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4.Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлага, зохицуулалтаар ханган ажиллаж, хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛД

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны дугаар сарын-ны өдрийн хуралдааны дугаар тэмдэглэлд:

“ХЭЛЭЛЦСЭН нь: “Монгол малчин” үндэсний хөтөлбөр батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөл.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Монгол малчин” үндэсний хөтөлбөр батлах тухай Засгийн газрын тогтоолын төслийг хэлэлцээд, хуралдааны явцад Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг тусгаж, Засгийн газрын тогтоол гаргахаар тогтов” гэжээ.

ГАРЫН ҮСЭГ

“МОНГОЛ МАЛЧИН” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Мал аж ахуйн үйлдвэрлэлийг олон зуун жилийн туршид эрхэлж ирсэн малчид нь Монгол орны түүхийг бүтээгч, нүүдэлчин ахуй, иргэншлийн өв соёлыг тээгч, нийгэм, эдийн засгийн томоохон давхарга юм.

Манай улсын нийт өрхийн 25,8 хувийг малтай өрх, үүний 73.5 хувийг малчин өрх эзэлж нийт хүн амын 19.4 хувь нь малчин өрхөд амьдарч, ажиллах хүчний 26,7 хувийг малчид бүрдүүлж байна. Малчин өрхийн эзлэх хувь 1999 онд 35.1 хувьд хүрч байсан бол 2018 оны эцэст 19.0 хувь болж буурсан ба малчдын тоо ч буурах хандлагатай байна. Малчдын тоо 2019 оны эхэнд 288,7 мянга болж, сүүлийн 2 жилийн дотор 22,7 мянгаар буурсан болно. Жилийн дөрвөн улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж буй малчин өрх 169.7 мянга, малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үржүүлж буй мал бүхий өрх 60.8 мянга, тавиул малтай өрх 0.4 мянга буюу 2 хувийг бүрдүүлж байгаа болно. Нийт малчин өрхийн 40.7 хувь хангайн бүсэд, 24.4 хувь баруун бүсэд, 21.2 хувь төвийн бүсэд, 12.3 хувь зүүн бүсэд, 1.4 хувь Улаанбаатар хотод байна. Нийт малчдын 9.8 хувь 15-24 насных, 23,5 хувь 25-34 насных, 29,1 хувь 35-44 насных, 21.2 хувь 45-54 насных, 11.2 хувь 55-64 насных, 5.2 хувь нь 65 ба түүнээс дээш насных байна.

Малчдын нөр их хөдөлмөрийн үр дүнд хүн амын гол нэрийн хүнсний хэрэгцээг хангаж, үндэсний үйлдвэрийн түүхий эдийг бэлтгэсээр иржээ. Гэвч малын тооны өсөлт, бэлчээрийн хомсдол, даац хэтрэлт, уур амьсгалын өөрчлөлт нь экологийн нөөцийн хязгаарлагдмал байдалд сөрөг нөлөөлөл, үүсгэж, мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх боломжийг хязгаарлаж эхэллээ. Мөн нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээ, шаардлагатай уялдуулж, мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрхлэх арга барилд өөрчлөлт оруулах, боловсронгуй болгох, малчдын оролцоо, үүрэг, хариуцлагыг улам бүр нэмэгдүүлэх шаардлага өдрөөс өдөрт нэмэгдэж байна.

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын 1.4.5, 2.1.2, 7.1.1, 7.1.3, 7.1.7, 7.1.8 дахь хэсэгт дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлж, мал аж ахуйн салбарын дотоодын үйлдвэрлэл, бүтээмж, хөрөнгө оруулалт, үр ашгийг өсгөх, хөдөөд ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэх, малчдын ая тухтай амьдрах, ажиллах нөхцлийг сайжруулах замаар мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх боломжийг бүрдүүлэх эдийн засаг, нийгмийн шаардлага, хэрэгцээ байна.

Мөн малчдын санал, санаачилга, нийгмийн идэвхи, оролцоог төрийн бодлогоор дэмжиж, тэдгээрийг мэдлэгжүүлэн хөгжүүлэх чиглэлд Засгийн газраас тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Иймд мал аж ахуйн салбар, малчдыг хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн урт, дунд хугацааны бодлого, нийгэм, эдийн засгийн шаардлага, эрэлт хэрэгцээнд суурилж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны А-172 дугаар тушаалаар байгуулсан Ажлын хэсгийн гишүүд, салбарын эрдэмтэн судлаачид, мал аж ахуйн салбарын судалгааны төрийн бус байгууллага, орон нутгийн мэргэжлийн байгууллага, малчдын төлөөлөл хамтарч, “Монгол малчин” үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулсан болно. Тус хөтөлбөрийн төслийг боловсруулахдаа Монгол

Улсын Их Хурлын 2009 оны 39 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-д тусгагдсан зорилтот арга хэмжээний хэрэгжилт, олон улсын болон бусад байгууллага, төсөл хөтөлбөрийн хүрээнд хийсэн судалгааны дүн, малчдын болон мал аж ахуйн салбарын зөвлөгөөн, хурал, семинараас гарсан зөвлөмж, хөтөлбөрийн төслийг боловсруулах нөхцөл байдлын дүн шинжилгээнд суурилж, хөтөлбөрийн төслийг боловсруулах, хэлэлцүүлэх явцад ирүүлсэн санал, шүүмжийг төсөлд харгалзан тусгалаа.

Түүнчлэн тус хөтөлбөрийн төслийн агуулгад Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд боловсруулахаар тусгагдсан “Малжуулах”, “Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах” хөтөлбөрийн агуулга, чиглэл, үйл ажиллагаа, өмнө нь боловсруулсан “Шинэ хөдөө-шинэ аян” хөтөлбөрийн үзэл баримтлалыг тус тус тусгаж, нэгтгэх зарчмыг баримтласан болно.

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг дэмжих, малчдын амьжиргаа, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн тус үндэсний хөтөлбөрийн төслийг үндсэн 5 зорилтын хүрээнд 2020-2024 оны хугацаанд хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 5 жилийн хугацаанд нийт 250,0 тэрбум төгрөг зарцуулах ба үүнд хувийн хэвшлээс 35,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийж, улсын төсвөөс зарцуулах 100,0 тэрбум төгрөгийн 60 хувь нь буюу 60,0 тэрбум төгрөг нь эргэн төлөгдөх хөнгөлттэй зээлийн нөхцлөөр зарцуулахаар байгаа юм. Мөн тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гадаадын төсөл, олон улсын байгууллагын санхүүжилтээс 75,0 тэрбум төгрөг, орон нутгийн төсвөөс 40,0 тэрбум төгрөгийг зарцуулах тооцоо гарч байна.

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

- Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах аянг өрнүүлж, малчдын мал маллах, аж ахуй эрхлэх арга барил, мэдлэг, чадавхийг сайжруулах, малчдын залуу халааг бэлтгэнэ.

- Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэх тогтолцоог шинэчлэх, чанарын үнэлэмж бий болгох, нэмүү өртгийн сүлжээний хамтын ажиллагааг нягтруулна.

- Малчин өрхийн бүтээмж, эдийн засгийн чадамж, нөөц ашиглалтыг нэмэгдүүлэх, байгальд ээлтэй, хариуцлагатай мал аж ахуйг тогтвортой эрхлэх, орлого, ашгаа өсгөх нөхцлийг сайжруулна.

- Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлийг бууруулж дасан зохицох, эрсдэл даах чадавхийг бататган сайжруулах үйл ажиллагааг эрчимжүүлж, тухайлсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

- Малчдын хамтын хоршил, эко санаачилга, хөрөнгө оруулалтыг идэвхжүүлж, орон нутагтаа ая тухтай ажиллах, амьдрах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулахад бодлогын дэмжлэг үзүүлнэ.

Иймд “Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл болон тус хөтөлбөрийн төсөлд санал авахаар танилцуулж байна. Хөтөлбөрийн төслийг боловсруулахтай холбогдсон судалгаа, хавсралтуудыг хавсаргав.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

МОНГОЛ МАЛЧИН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Мал аж ахуйн үйлдвэрлэлийг олон зуун жилийн туршид эрхэлж ирсэн малчид нь Монгол орны нүүдлийн соёл иргэншил, түүхийг бүтээгч, өв соёлыг тээгч, нийгэм, эдийн засгийн томоохон давхарга юм. Манай улсын нийт хүн амын 19.4 хувь нь буюу 617.3 мянган хүн малчин өрхөд амьдарч, ажиллах хүчний 26,7 хувийг малчид бүрдүүлж, нийт өрхийн 25,8 хувийг малтай өрх, үүний 73.5 хувийг малчин өрх эзэлж байна.

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээ, шаардлагатай уялдан мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх, байгальд ээлтэй байх харилцаанд малчдын оролцоо, үүрэг, хариуцлага улам бүр нэмэгдэх боллоо.

Монгол Улсын Их Хурлаас сүүлийн үед баталсан Малын генетик нөөцийн тухай хууль, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд малчдын зарим эрх, үүргийг нарийвчлан тодорхойлоод байна. Түүнчлэн Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, Төрөөс малчдын талаар баримтлах бодлого, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Гурван тулгуурт хөгжлийн бодлогын баримт бичигт малчин өрх, малчдын талаар авч хэрэгжүүлэх тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн болно.

Иймд хууль тогтоомж, төрийн урт, дунд хугацааны бодлогын хэрэгжилтийг хангах, малчдын үйл ажиллагаа, амьжиргаанд шууд болон шууд бусаар нөлөөлдөг хүчин зүйлсийн нөлөөллийг бууруулах, мал аж ахуйн салбарыг тогтвортой хөгжүүлэхэд төрийн зүгээс малчдыг дэмжих, малчдын идэвх санаачилга, хувь нэмэр, оролцоог сайжруулах, малчдыг чадавхижуулах, тэдгээрийн хөгжлийн тулгамдсан зарим асуудлуудыг шийдвэрлэх шаардлага нь энэхүү хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болсон юм.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

2.1. Энэхүү үндэсний хөтөлбөр (цаашид “хөтөлбөр” гэх)-ийн зорилго нь малчдыг мэдээллээр хангах, хөгжүүлэх, орон нутагтаа ая тухтай ажиллах, амьдрах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, бүтээмж, орлого, ашгийг нь өсгөх, чадавхижуулахад чиглэгдэнэ.

Гурав. Хөтөлбөрийн зорилт

3.1. Хөтөлбөрийн зорилгыг дараахь зорилтоор хэрэгжүүлнэ:

3.1.1.Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах аян өрнүүлж, тэдгээрийн мэдлэг, туршлага, чадавхийг сайжруулах, хөгжүүлэх, малчдын залуу халааг бэлтгэх;

3.1.2.Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоонд чанарын үнэлэмж бий болгох, нэмүү өртгийн сүлжээнд малчдын оролцоог идэвхжүүлэх;

3.1.3.Малчид, малчин өрхийн үйлдвэрлэлийн бүтээмж, нөөц ашиглалтыг нэмэгдүүлэх, орлого, ашгийг өсгөх, эдийн засгийн чадамжийг сайжруулах;

3.1.4.Малчдын хамтын хоршил, эко санаачилга, хөрөнгө оруулалтыг идэвхжүүлж, байгальд ээлтэй, хариуцлагатай мал аж ахуйг тогтвортой эрхлэхэд чиглэгдсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.1.5.Малчдын орон нутагтаа ая тухтай ажиллах, амьдрах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулахад бодлогын дэмжлэг үзүүлэх;

Дөрөв. Хөтөлбөрийн зорилтот бүлэг, хамрах хүрээ

4.1.Хөтөлбөрийн зорилтот бүлэг нь үндэсний өв соёлыг тээгч, уламжлалт мэдлэгийг түгээн дэлгэрүүлэгч Монгол Улсын иргэн- малчид байна.

4.2.Хөтөлбөрийн хамрах хүрээнд дор дурьдсан малчид хамаарна:

4.2.1.малын ашиг шимээр өрхийн үндсэн орлогоо бүрдүүлж, жилийн дөрвөн улирлын туршид өөрийн өмчийн малыг маллаж байгаа 16-аас дээш насны малчин;

4.2.2.мал бүхий этгээдийн өмчлөлийн малыг гэрээний үндсэн дээр маллаж байгаа туслах малчин;

4.2.3.суурин болон хагас суурин аж ахуйд мал бүхий этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр төрөлжсөн үүлдрийн малыг тэжээж, арчилж, маллаж байгаа малчин, саальчин;

4.2.4.сайн дурын үндсэн дээр зохион байгуулалтад орж, хамтран ажиллах хэлбэрээ харилцан тохиролцож, баталгаажуулсан малчдын бүлэг

Тав. Хөтөлбөрийн зорилтот үйл ажиллагаа

5.1."Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах аян өрнүүлж, тэдгээрийн мэдлэг, туршлага, чадавхийг сайжруулах, нэвтрүүлэх, залуу малчдын халааг бэлтгэх" зорилтыг дараахь үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлнэ:

5.1.1."Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах аян"-г улсын хэмжээнд өрнүүлж, малчдын мал маллах ухаан, аж ахуй эрхлэх арга барил, туршлагыг дэлгэрүүлсэн тэргүүний сум, дүүрэг, аймгийг жлл бүр шалгаруулах;

5.1.2.Малчдад зориулсан сургалт, мэдээллийн тэнхимийг сум бүрт бий болгож, төрийн бодлого, хууль эрх зүйн мэдлэг олгох, харилцан туршлага солилцох таатай орчинг бүрдүүлэх, малчид жигд оролцох боломжоор хангах;

5.1.3.Орон нутгийн онцлогтой, мал аж ахуйд хамааралтай уламжлалт мэдлэгийг бүртгүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд малчдын оролцоог нэмэгдүүлэх;

5.1.4.Малчинд мэргэжлийн үнэмлэх, малчин өрхөд баталгааны тэмдэг олгох, хэрэглэхтэй хоблогдсон хууль, журам, шаардлага, ач холбогдлыг таниулах;

5.1.5.Мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг ашиглан малчдад хэрэгцээт мэдээллийг шуурхай хүргэх, энэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж орон зайн хамаарлыг бууруулах;

5.1.6.Залуу малчдад зориулсан тухайлсан сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх, туршлага судлуулах;

5.1.7.Дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, нийгмийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцүүлж, үр ашигтай, “ухаалаг” аж ахуй эрхлэх мэдлэгийг түгээж, малчдыг чадавхижуулах;

5.2.”Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоонд чанарын үнэлэмж бий болгох, нэмүү өртгийн сүлжээнд малчдын оролцоог идэвхжүүлэх” зорилтыг дараахь үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлнэ:

5.2.1.Сум бүрт мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг төвлөрүүлэн бэлтгэх, үйлдвэрт нийлүүлэх зорилготой малчдын хувь нийлүүлсэн оролцоотой “Түүхий эдийн бэлтгэл, борлуулалтын төв”-ийг байгуулж, өнөөгийн тогтолцоог шинэчлэх;

5.2.2.”Түүхий эдийн бэлтгэл, борлуулалтын төв” нь үндэсний үйлдвэрүүдтэй тогтвортой нөхцлөөр гэрээ байгуулж, дүгнэдэг, үнэ тогтворжуулах системтэй болох, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээнд малчид харилцан ашигтай оролцох хамтын ажиллагааг эрчимжүүлэх;

5.2.3.Мал сүргийн бүтэц, нөхөн эргэлтийг тооцоолох, нөөцийг тодорхойлох, төлөвлөх нэгдсэн арга зүйг улсын хэмжээнд нэвтрүүлж, мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг шинжлэх ухааны үндэслэлтэй болгох;

5.2.4.Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг малчин өрх, мал бүхий этгээд тус бүрээр тодорхойлох, чанарыг үнэлэх, бүртгэлжүүлэх, баталгаажуулах нэгдсэн системийг хөгжүүлэх;

5.2.5.Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэхэд баримтлах стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг малчид, мал бүхий иргэд, хуулийн этгээдэд таниулах, сурталчлах;

5.2.6.Чанараас хамаарсан үнэ, үнэлгээний ач холбогдлыг малчдад таниулах ажлыг сум бүрт зохион байгуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөөг тогтмол өгч, сурталчлах;

5.2.7.Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах, үнийн тогтворгүй байдлыг арилгахад чиглэгдсэн эдийн засгийн хөшүүргийн бодлогыг хэрэгжүүлэх;

5.2.8.Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний төрөл, ангилал, чанар, үнийг сум, дүүрэг, аймаг, нийслэл тус бүрээр нийтэд мэдээлэх, өөрчлөлт, өрсөлдөх чадварт нь дүн шинжилгээ тогтмол хийх ажлыг зохион байгуулах.

5.3.”Малчид, малчин өрхийн үйлдвэрлэлийн бүтээмж, нөөц ашиглалтыг нэмэгдүүлэх, орлого, ашгийг өсгөх, эдийн засгийн чадамжийг сайжруулах” зорилтыг дараахь үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлнэ:

5.3.1.Малчин өрх, малчдын үйлдвэрлэлийн бүтээмж, нөөц ашиглалтыг нэмэгдүүлэх хүчин зүйлсийг тодорхойлж, эдийн засгийн төлөвлөлтөд нь дэмжлэг үзүүлэх замаар малчдын орлого, ашиг, чадамжийг нэмэгдүүлэх;

5.3.2. Малчин, малчин өрхийн гишүүдийн хүсэлтээр мал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд биет үнэлгээ хийлгэх, хөдлөх хөрөнгийг эдийн засгийн эргэлтэнд оруулахад чиглэсэн зөвлөх, нэвтрүүлэх үйлчилгээг дэмжин хөгжүүлэх;

5.3.3. Малчин өрх үйлдвэрлэж байгаа түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг баталгаажуулахад баталгааны тэмдэг хэрэглэх, бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын хариуцлагатай тогтолцоонд үе шаттай шилжих;

5.3.4. Малчдын хөдөлмөрийн бүтээмж, үнэлэмжийг тогтоох арга зүйг бий болгож, нэвтрүүлэх;

5.3.5. Малын чанар, ашиг шимийг сайжруулж өрхийн орлого, үр ашгийг өсгөх боломж, ач холбогдлыг малчид, мал бүхий иргэдэд таниулах, сүм, баг бүр мал сүргийн үржил селекцийн ажлын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх;

5.3.6. Малын төрөл бүрийн өвчнөөс урьдчилан сэргийлэх замаар малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх ажлыг үнэлж, дүгнэдэг болох;

5.3.7. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж, нөөц ашиглалтын түвшний өсөлтийн үзүүлэлтийг “Улсын тэргүүний малчин, сум, дүүрэг шалгаруулах” болзолд тусгах, бүтээмжийг үнэлдэг, урамшуулдаг болох;

5.3.8. Малчдын эдийн засгийн чадамжийг сайжруулахад чиглэгдсэн хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны цар хүрээг тэлэх.

5.4. “Малчдын хамтын хоршил, эко санаачилга, хөрөнгө оруулалтыг идэвхжүүлж, байгальд ээлтэй, хариуцлагатай мал аж ахуйг тогтвортой эрхлэхэд чиглэгдсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх” зорилтыг дараахь үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлнэ:

5.4.1. Малчдын хамтын хоршил, эко санаачилга, хөрөнгө оруулалтыг идэвхжүүлж, бэлчээрийг зохистой ашиглах, сайжруулах, хамгаалах, менежментийг үр дүнтэй хэрэгжүүлэх

5.4.2. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэйгээр малчдын, малчин өрхийн амьжиргаанд нөлөөлөх хүчин зүйлс, ирээдүйн чиг хандлагыг тодорхойлж, малчдад таниулах, сурталчлах, хариу арга хэмжээний төлөвлөгөөг сум, аймаг бүр боловсруулж, хэрэгжүүлэх;

5.4.3. Байгальд ээлтэй, хариуцлагатай мал аж ахуйг тогтвортой эрхлэх, мал аж ахуйн үйлдвэрлэлийн хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулахад чиглэсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх;

5.4.4. Малчдын оролцоо, орон нутгийн хөрөнгө оруулалтад тулгуурлан малын тэсвэрт чанарыг бататгах, мал аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэл даах, дасан зохицох чадавхийг сайжруулах, техник, технологийн дэвшил, инновацийг нэвтрүүлэх;

5.4.5. Малчид, малчин өрхийн орлогыг бууруулахгүйгээр бэлчээрийн даацаас хэтэрсэн малын тоог үе шаттай бууруулах, хэрэгцээнээс давсан малыг борлуулах үе дүнтэй арга, тэргүүн туршлагыг сум, аймаг, улсын түвшинд нэвтрүүлэх;

5.4.6. Малчдын санал, санаачилгаар цас борооны ус тогтоох, усан сан, нуур, хөв, цөөрөм байгуулах, сэргээгдэх эрчим хүч ашиглах, худгийн ашиглалт, хамгаалалтыг гэрээгээр хариуцах санаачилгыг дэмжиж, хэрэгжүүлэх;

5.4.7. Бэлчээрт хор хөнөөл учруулж байгаа мэрэгч амьтан, шавжтай тэмцэхэд малчид, мал бүхий этгээдийн оролцоог нэмэгдүүлэх, бүртгэл, хяналттай болгох.

5.4.8. Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийн төлөвлөлт, стратеги, хөрөнгө оруулалтын бодлогыг боловсруулах, экологийн үнэлгээ хийхэд олон улсын арга зүйг нэвтрүүлэх.

5.5. "Малчдын орон нутагтаа ая тухтай ажиллах, амьдрах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулахад бодлогын дэмжлэг үзүүлэх" зорилтыг дараахь үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлнэ:

5.5.1. Малчин ахуй, өв соёлд суурилсан аялал жуулчлал, түүнийг дагасан үйлчилгээ, эко бүтээгдэхүүн борлуулалтыг хөгжүүлж, малчдын ногоон үйлдвэрлэл эрхлэх ур чадварыг дээшлүүлэн, орлогыг нэмэгдүүлэх

5.5.2. "Шинэ хөдөө", "Залуу малчин", "Сарлаг", "Тэмээ" зэрэг тухайлсан төсөл, дэд хөтөлбөрийг орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлж, малчдын орлого, ашгийг нэмэгдүүлэх;

5.5.3. Малчин өрхийн эргэлтийн хөрөнгийн үнэлгээ, малын бүртгэлийн системд суурилан банк, санхүүгийн, зээлийн батлан даалтын болон даатгалын үйлчилгээг малчдад дарамтгүйгээр, шуурхай үзүүлэх боломжийг бүрдүүлэх;

5.5.4. Малчид өвлүүлэх үл хөдлөх хөрөнгөтэй болохыг дэмжиж, ипотекийн болон арилжааны банкны хөтөлбөрт хамруулах, зээлийн хөнгөлөлт үзүүлэх таатай нөхцлийг бүрдүүлэх;

5.5.5. Малчдын хүүхэд бага ангид шинээр элсэн суралцахтай холбогдон малчин өрхөд үүсч байгаа хүндрэлийг багасгахад чиглэгдсэн шинэ арга барилыг нэвтрүүлэх;

5.5.6. Байгалийн давагдашгүй хүчин зүйлсийн нөлөөлөл, эрэлт, хэрэгцээ, шаардлагаас үүдэн "Малжуулах" төслийг хэрэгжүүлэх асуудлыг орон нутгийн бодлогоор шийдвэрлэх;

5.5.7. Орон нутгийг хөгжүүлэх арга хэмжээнд малчдын идэвхи, оролцоог сайжруулж, малчдын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, мал аж ахуйг тогтвортой эрхлэхийг дэмжин хөгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг хамтын оролцоогоор бүрдүүлэх;

5.5.8. "Өнтэй өвөл, хавар" арга хэмжээг жил бүр тогтмол зохион байгуулж, малчин өрх, мал бүхий этгээдийн өвс, хадлан, тэжээл бэлтгэх, дүгнэх шалгуурыг баталгаажуулж, болзолтой болгох;

5.5.9. Малчдыг тогтмол орлого, хуримтлалтай болгох зорилгоор мал, мах бэлтгэн нийлүүлэх арга хэмжээг идэвхжүүлж, мал сүргийг экологийн даацад нийцүүлэх үйл ажиллагаанд оролцогч талуудын хамтын ажиллагааг нягтруулах;

5.5.10. Малчдын хэрэглээ, шаардлагад нийцсэн ахуйн, соёл урлагийн болон бусад үйлчилгээг сайжруулах, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд хамрагдах ажлыг идэвхжүүлэх, ач холбогдлыг сурталчлах;

5.5.11. Малчид ая тухтай амьдрах, аж ахуйгаа эрхлэх, хөдөлмөрөө хөнгөвчлөх боломж, нөхцөлийг сайжруулж, техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, ашиглах.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

6.1. Хөтөлбөрийн зорилго, зорилтот үйл ажиллагааг хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөгөөр хэрэгжүүлнэ.

6.2.Хөтөлбөрийн зорилтот зарим үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шалгуур, шаардлага тавина.

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

7.1.Хөтөлбөрийг 2020-2024 оны хугацаанд хэрэгжүүлнэ.

Найм. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

8.1. Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

| № | Зорилт | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин, он | Зорилтот түвшин, он |
|----|--|--|-------------|------------------|---------------------|
| | | | | 2018 | 2024 |
| 1. | Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах аянг өрнүүлж, малчдын мал маллах, аж ахуй эрхлэх арга барил, мэдлэг, чадавхийг сайжруулах, малчдын залуу халааг бэлтгэх; | аян өрнүүлэх шийдвэр | тоо | 0 | 22 |
| | | аян хэрэгжүүлэх засаг захиргааны нэгж, байгууллага | тоо | 0 | 359 |
| | | малчдад зориулсан сургалт, мэдээллийн тэнхим | тоо | 0 | 331 |
| | | сургалтад хамрагдах малчид | тоо | 12.972 | 200.000 |
| | | малчдын интернэт хэрэглээний өөрчлөлт | тоо | 32.000 | 80.000 |
| | | тэргүүн туршлага судалсан, нэвтрүүлсэн малчид | тоо | 43.500 | 100.000 |
| | | 16-44 насны малчдын тооны өөрчлөлт | тоо | 180.100 | 190.000 |
| 2. | Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэх тогтолцоог шинэчлэх, чанарын үнэлэмж бий болгох, нэмүү өртгийн сүлжээний хамтын ажиллагааг нягтруулах; | сумын түүхий эдийн загвар хоршоо | тоо | 3 | 235 |
| | | малын ашиг шимийн түвшинг шинэчилсэн стандарт | тоо | 0 | 5 |
| | | шинэчилсэн техникийн зохицуулалт | тоо | 0 | 3 |
| | | чанарын лаборатори | тоо | 0 | 232 |

| | | | | | |
|----|---|---|-------------------------------|--------|---------|
| | | чанар шалгах тоног төхөөрөмжийн хангамж | хувь | 0 | 70 |
| | | чанарын өөрчлөлт гаргах түүхий эд, бүтээгдэхүүний төрөл | тоо | 0 | 5 |
| 3. | Малчин өрхийн бүтээмж, эдийн засгийн чадамж, нөөц ашиглалтыг нэмэгдүүлэх, байгальд ээлтэй, хариуцлагатай мал аж ахуйг тогтвортой эрхлэх, орлого, ашгаа өсгөх нөхцлийг сайжруулах; | мал аж ахуйн салбарын бүтээмж | хувь | 6,1 | 10,8 |
| | | сүүний нөөц ашиглалтын түвшний өөрчлөлт | хувь | 34 | 68 |
| | | байгальд ээлтэй, хариуцлагатай мал аж ахуйн шалгуур үзүүлэлтийн баталгаажуулалт | хувь | 0 | 30 |
| | | байгальд ээлтэй технологи, инновацийн бүтээгдэхүүний өөрчлөлт | технологийн тоо | 2 | 10 |
| | | | инновацийн бүтээгдэхүүний тоо | 5 | 15 |
| 4. | Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлийг бууруулж дасан зохицох, эрсдэл даах чадавхийг бататган сайжруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх; | хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ | тоо | 2 | 5 |
| | | бүдүүн тэжээл бэлтгэлийн хэмжээ | мян.тн | 1298,3 | 1947,5 |
| | | малын тэсвэрт чанарын судалгаа | хувь | 0 | 5 |
| | | малчид ашиглалт, хамгаалалтыг хариуцсан худаг | хувь | 8 | 30 |
| | | бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэхэд малчдын оролцооны өөрчлөлт | хувь | | |
| 5. | Малчдын хамтын хоршил, санаачилга, хөрөнгө | малчдын хоршооны тооны өөрчлөлт | давхардсан тоогоор | 99.500 | 115.000 |
| | | малчдын бүлгийн тооны өөрчлөлт | давхардсан тоогоор | 48.300 | 55.000 |
| | | малчдын нөхөрлөлийн тооны өөрчлөлт | давхардсан тоогоор | 24.828 | 20.000 |

| | | | | |
|---|---|---------------|---------|---------|
| оруулалтыг идэвхжүүлж, орон нутагтаа ая тухтай ажиллах, амьдрах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулахад бодлогын дэмжлэг үзүүлэх; | малчин ахуйд суурилсан аялал жуулчлалын эрэлт өөрчлөлт | хувь | 8 | 30 |
| | малчдын ХАА-н техник, хэрэгслийн тооны өөрчлөлт | хувь | 27,0 | 50,0 |
| | малтай өрхийн сарын дундаж мөнгөн орлогын өөрчлөлт | мян.төг | 936,4 | 1404,6 |
| | зээлтэй малчдын эзлэх хувийн өөрчлөлт | хувь | 39,1 | 30,0 |
| | нийгмийн даатгалд хамрагдсан малчид | тоо | 75.600 | 100.000 |
| | эрүүл мэндийн даатгалд хамрагдсан малчид | тоо | 197.400 | 210.000 |
| | мал аж ахуй, малчдад зориулсан улсын төсвийн санхүүжилт | тэрбум төгрөг | 80,0 | 100,0 |

Ес. Хөтөлбөрийн үр дүн

9.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ:

9.1.1. Малчдын мэдлэг, чадавхи сайжирснаар мал аж ахуй эрхлэх арга барил боловсронгуй болж, шинэ мэдлэг, техник, технологийг нэвтрүүлэх үйл ажиллагаанд дэвшил гарна.

9.1.2. Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын хяналт сайжирч, бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо, үнэ цэнийн сүлжээнд өрсөлдөх чадварын өөрчлөлт, дэвшил гарна.

9.1.3. Малчин өрхийн нөөц ашиглалт, бүтээмжийн түвшин өсч, мал аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэл, малчдын орлого, ашиг нэмэгдэнэ.

9.1.4. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэл даах чадавхийг бататган сайжруулах үйл ажиллагаа эрчимжиж, мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх, хөгжүүлэх эрх зүй, хөрөнгө оруулалтад эерэг нөлөөлөл авчирна.

9.1.5. Хөдөөгийн хөгжилд малчдын оруулах санаачилга, хувь нэмэр голлох үүрэг гүйцэтгэж, малчдад хандсан төрийн бодлого, татвар, санхүүгийн тогтвортой, таатай орчинг бүрдэж, малчдын орон нутагтаа ая тухтай ажиллах, амьдрах нөхцөл, нийгмийн баталгаа сайжирна.

Арав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилт

10.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийг дараахь эх үүсвэрээр бүрдүүлнэ:

10.1.1. малчид, мал бүхий этгээдийн хөрөнгө оруулалт

10.1.2. улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;

10.1.3. гадаад, дотоодын байгууллагын хөрөнгө оруулалт

10.1.4. арилжааны банкны эх үүсвэр;;

10.1.5. олон улсын төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалт, зээл, хандив, тусламж;

10.1.6. бусад эх үүсвэр.

Арван нэг. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ

11.1. Хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийн жил бүийнр хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулна.

11.2. Хөтөлбөрийн 11.1-д заасан хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.

11.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтэд үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.